


ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН
ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

2018 оны 1,2 сарын дугаар




“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УТҮГ



2018 оны 1,2 сарын дугаар

2018 ОНЫГ “САХИЛГА БАТ, ДЭГ ЖУРМЫГ ЧАНГАТГАХ ЖИЛ” БОЛГОН ЗАРЛАЖ ХОЛБОГДОХ АРГА ХЭМЖЭЭГ ШАТ ДАРААЛАЛТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАН АЖИЛЛАЖ БАЙНА

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017.11.20-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2017.11.22-ны өдрийн “Албан даалгавар хэрэгжүүлэх тухай” А/74 дүгээр тушаалаар батлагдсан Хөдөлгөөн зохицуулалтын төвөөс зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж, “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2018.01.02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар 2018 оныг төвийн хэмжээнд “Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах жил” болгон зарлаж холбогдох арга хэмжээг шат дараалалтай зохион байгуулан ажиллаж байна.



ЗТХЯ-НЫ ХАРЬЯА ТЗДТБХЗГ-Т САНАЛ ХҮРГҮҮЛЛЭЭ

EN14478-2005 Төмөр замын хэрэглээ-Тоормослолт-Тайлбар толь стандартын орчуулгын төсөлд Хөдөлгөөн зохицуулалтын төвөөс тусгах саналыг 2018.01.11-ний 18 тоот албан бичгээр, Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Төмөр замын техник ашиглалтын дүрэмд тусгах саналыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 230 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралд танилцуулах, хэлэлцүүлэх зорилгоор 2018.01.19-ний өдөр ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т хүргүүлжээ.



2018 оны 1, 2 сарын дугаар

“УБТЗ” ХНН-ИЙН ЗАМЫН –ҮҮД, САЙНШАНД, АЙРАГ, БОР-ӨНДӨР ЧОЙР ӨРТӨӨНД АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАЛАА



Ш у г а м
замын урд хэсэгт
х у р и м т л а г д с а н
ачааны бөөгнөрлийн
хэмжээ, нөхцөл
байдлыг газар дээр
нь судлан дүгнэлт
гаргаж, галт
тэрэг, ачаа, хөдлөх
б ү р э л д э х ү ү н и й
солилцоохийгдэжбуй
ажилтай танилцах,
ачааны баримт
бичиг бүрдүүлэлт,
ачаа эргэлт, хэсгийн
хурд, зүтгүүр вагоны

хуваарилалтыг судлах зорилгоор “ГТХЗНТ”- УТҮГ-ын Захирал Т.Ариунбаатар, Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Оюунбат, Д.Бат-Оргил, Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Эрдэнэтулга нар 2018 оны 1 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд Замын-Үүд, Сайншанд, Айраг, Бор-Өндөр, Чойр өртөөдөд албан томилолтоор ажиллалаа.





2018 оны 1,2 сарын дугаар


1-Р САРЫН СТАТИСТИК МЭДЭЭ

Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт



Зорчигч тээвэрлэлт 2018 оны нэгдүгээр сард 220.5 мян.зор тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.9%-аар өссөн, ачаа тээвэрлэлт нь 2018 оны нэгдүгээр сард 2127.2 мян. тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 25.3%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Дамжин өнгөрсөн ачаа /тонноор/



Дамжин өнгөрсөн ачаа 2018 оны нэгдүгээр сард 270733.3 тн ачсан нь өнгөрсөн оны мөн үеэс 100630.2 тн буюу 59.2 хувиар өссөн байна.

АЧИЛТ- АЧААНЫ ТӨРЛӨӨР
2018 I



2018 оны эхний нэг сард ачилт 1633.60 мян.тн өмнөх оны мөн үетэй харьцуулбал 25.1% өссөн, нэгдүгээр сард Нүүрс, Төмрийн хүдэр, Мод модон материал, Зэс молибдений баяжмал өссөн үзүүлэлттэй байна.



2018 оны 1,2 сарын дугаар

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА БА ХЯНАЛТЫН АРГА СТАНДАРТЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛЛАА

Дэд бүтцийн харилцаа холбооны мэдээлэл болон аюулгүй байдлын нэгдсэн мэдээллийн сан, Төмөр замын ачааны вагон, үйлдвэрлэлийн объект ТВ 10031-2009, ГОСТ 33435-2015 Хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй ажиллагаа, хяналт, удирдлагын тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага ба хяналтын арга стандартын баримт бичгийг орчуулан боловсрууллаа.



УСТРОЙСТВА УПРАВЛЕНИЯ,
КОНТРОЛЯ И БЕЗОПАСНОСТИ
ЖЕЛЕЗНОДОРОЖНОГО
ПОДВИЖНОГО СОСТАВА

Требования безопасности и методы контроля

Издание официальное



中华人民共和国行业标准

铁路货车车辆设备设计规范

Code for design of railway freight car rolling stock facilities

TB 10031—2009
J 73—2009

主编单位：中铁第四勘察设计院集团有限公司
批准部门：中华人民共和国铁道部
施行日期：2009年7月6日

中国铁道出版社

2009年·北京

“ТӨМӨР ЗАМЫН ТЕХНИК АШИГЛАЛТЫН ДҮРЭМ”-ИЙГ ЗАХИРГААНЫ ХУУЛЬД ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛД ОРОЛЦЛОО

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017.11.15-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 230 дугаар тушаал, ЗТХЯ-ны Зам тээврийн хяналтын хэлтсийн 2018.01.16-ны өдрийн “Сайдын тушаалын хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай” 10а/237 тоот албан бичгийн хүрээнд Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан “Төмөр замын техник ашиглалтын дүрэм”-ийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах Ажлын хэсэг 2018.01.22-28-нд Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн Техникийн бодлого, зураг төслийн төвийн хурлын танхимд хуралдлаа. Тус хуралд төвийн төлөөлөл оролцож Төмөр замын техник ашиглалтын дүрэмд хөдөлгөөн зохицуулалтын төвөөс тусгах саналыг танилцуулж хэлэлцүүлсэн юм.



2018 оны 1,2 сарын дугаар

СУУРЬ БҮТЦИЙН 2018 ОНЫ 1-Р САРЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГИЙН ТАСАЛДЛЫН ТАЙЛАН

Өмнөх 12 сартай харьцуулахад зорчигчийн галт тэрэгний явуулалт 1,24%- иар өсөж, өнгөрүүлэлт 0,36%-иар буурч, ачааны галт тэрэгний явуулалт 0,04%-иар өсөж, өнгөрүүлэлт нь 0,76%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Зурмагийн тасалдал:

2018 оны 1-р сард нийт 140 тасалдал, 170,1 галт тэрэг цагийн барилт үүсэж, 17,31 сая төгрөгийн хохирол гарсан байна.

Өмнөх сарын тасалдлын тоо, галт тэрэгний цагийн барилт, хохирлын хэмжээтэй харьцуулахад:



График №3



График №4





2018 оны 1,2 сарын дугаар

СУУРЬ БҮТЦИЙН 2018 ОНЫ 2-Р САРЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГИЙН ТАСАЛДЛЫН ТАЙЛАН

Өмнөх 1-р сартай харьцуулахад зорчигчийн галт тэрэгний явуулалт 0,16%-иар, өнгөрүүлэлт 0,93%-иар, ачааны галт тэрэгний явуулалт 0,16%-иар, өнгөрүүлэлт нь 0,57%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зурмагийн тасалдал:

2018 оны 2-р сард нийт 117 тасалдал, 153,1 галт тэрэг цагийн барилт үүсэж, 13,56 сая төгрөгийн хохирол гарсан байна.

Өмнөх сарын тасалдлын тоо, галт тэрэгний цагийн барилт, хохирлын хэмжээтэй харьцуулахад:



График №3



График №4





2018 оны 1,2 сарын дугаар

“АВИЛГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ҮЛ ТЭВЧИХ” УРИАЛГА ГАРГАЛАА



УРИАЛГА



“ГТХЭНТ” УТУГ-ЫН НИЙТ АЖИЛТНУУДАД ХАНДАН
УРИАЛАХ НЬ:

“Бица засаад гэрээ зас Гэрээ засаад төрөө зас” Нэгжээ хэвч сургаалтай!

- Дээр үеэс уламжлагдсан ирсэн уг сургаалийн дагуу улс эх орны хөгжилт хувь хүний
ичлээл зүтгэл, үнэмч шударга байдал, эх оронч сэтгэлгээнээс эхэлдэг тул хүн бүр дор
бүрнээ хичээж, өс зүйн зөрчил, хууль бус үйлдлийг үл тэмцээгээ.

- Эх орны цаашдын хөгжил, хүмүүнтэй иргэний, ардчилсан нийгмийг цогцлоон бүтээхэд
хувь нэмрээ оруулахын тулд албан тушаалтан нь хуулиа дээдэлж, авлига, ашиг
сонирхлын зөрчлөөс ангида байж, албан үүргээ итгэл хүлээжүйц, төгш мэдээтэй,
хармуцлагатайгаар гүйцэтгэжэ.

- Төрийн идагшлага болон амттан албан тушаалтан байдлаа өөрт ашигтайгаар
үйсүүлэн ашиглаж, сонгог шалгалт үзүүлжүүлэн авах, хөгжилтэй үйлчлүүлж, өөрийн
болон өөртэй нь хамдарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн
захирагвсны шийдвэр гаргаж, үндсрхж, хармуцлага хүлээлж, албан үүргээ гүйцэтгэсний
төлөө аливаа төлбөр авах гм Нийтийн албанд нийтлэн болон хувийн ашиг сонирхлыг
зөхиүүлж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж тухай хуульд заасан ашиг
сонирхлын зөрчлөөс ангида байжээ.

- Төрийн албан хаагчдын өс зүйн дүрмээ чандлан сахж, аливаа шийдвэр гаргахдаа
танил тал, харагч чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, үзэл бодлоор нь
ялгаварлахгүйгээр тэгш байж, хамт олон, хамтран ажилладаг байгууллагуудтай
хүндэтгэлтэй харилцажэ.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангида байж, чадсанар Монгол улсынхаа
хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, ардчиллын үнэг зүйлсээ хамгаалж чадна.

“ГТХЭНТ” УТУГ-ЫН ХАМТ ОЛОН

2018 оны 02 дугаар сарын 27

“Авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих” уриалга гаргаж төвийн мэдээллийн самбарт байршуулсан. Мөн онлайн орчинд аюулгүй ажиллах 10 зөвлөмж, “Авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих” сурталчилгааны материалуудыг төвийн мэдээллийн самбарт байршуулж албан хаагчдад танилцуулагдлаа.

АВЛИГА Ба

USAID The Asia Foundation

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ
ТӨРИЙН АЛИВАА ШИЙДВЭРИЙГ ТӨРИЙН АЛБАН
ТУШААЛТНУУД ГАРГАХДАА НИЙГМИЙН САЙН
САЙХНЫ ТӨЛӨӨ БҮС ӨӨРТ АШИГТАЙ
БАЙДЛААР ГАРГАВАЛ ТҮҮНИЙ ХОР УРШГИЙГ БИД
НУРУУНДАА ҮҮРЭХ БОЛДОГ.

АШИГ Бидний хүүхдүүд сурах
СОНИРХЛЫН сургуульдаа сурч чадахгүй,
ЗӨРЧИЛ хүүхдийн маань цэцэрлэгийн
засвар хийгдэхээ больж,
бид эмнэлгийн үйлчилгээг үнэ
төлбөргүйгээр авах эрхээ эдэлж
чаддаггүй.

АВЛИГА ХЭЭЛ ХАХУУЛЬ
Бидний худалдан авсан бараа
бүтээгдэхүүний үнэд шингэсэн байдаг
тул хямд авч болох зүйлийнхээ
төлөө илүү өндөр үнэ төлсөөр
байна.

Мэдээллийн эх үүсвэрүүд: Ашиг сонирхлын зөрчлийг тухай мэдлэг, ашиглаж
болон ашиглах тухай хөгжүүлэх төслийн үзүүлэлт 2013.
/Нийгмийн Дотоод Эдийн Засагчдын Хэлтэс/

№10

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

USAID The Asia Foundation

ГЭЖ ЮУ ВЭ?

ТРАНСПЕРЕНСИ ИНТЕРНЕЙШНЛ БАЙГУУЛЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ:

“Ашиг сонирхлын зөрчил гэдэг нь Төрийн албан хаагч төрийн ашиг сонирхолд болон улсын ашиг сонирхолд үйлчлэхээсээ илүү төрийн нэрийн өмнөөс өөрт олгогдсон эрх мэдлээ ашиглаж өөрийн үзэмжээр хувийн ашиг сонирхолдоо үйлчлэх нөхцөл байдлыг ойлгоно” гэжээ.

Гэр бүл, найз нөхдийн сонирхол

Ажил, мэргэжлийн нэр хүнд, үнэт зүйл

Хувийн сонирхол

Байгууллагын нэр хүнд, олон нийтийн итгэл

Хувийн үнэт зүйлс

Төрийн үйлчилгээ

Мэдээллийн эх үүсвэрүүд: Ашиг сонирхлын зөрчлийг тухай мэдлэг, ашиглаж
болон ашиглах тухай хөгжүүлэх төслийн үзүүлэлт 2013.
/Нийгмийн Дотоод Эдийн Засагчдын Хэлтэс/

№8



2018 оны 1,2 сарын дугаар

ТӨВИЙН МЭДЭЭЛЛИЙН ЦАГААР ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Захиргаа, санхүү хэлтсийн мэдээллийн цагаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалт зохион байгуулж ГТХЗНТ-УТҮГ-ын ажилчид хамрагдлаа.

“
Мөн “Хувь хүний болон байгууллагын нууц” сэдэвт сургалт зохион байгууллаа. Монгол Улсын хууль тогтоомжид “Хувь хүний нууц болон “Байгууллагын нууц”-ын тухай эрх зүйн орчин хэрхэн тусгагдсан байдаг, ач холбогдлын тухай танилцуулсан юм.



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН
ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



“Юнител” ХХК-ийн Төмөр зам хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж төвийн албан хаагчдын хүсэлтийн дагуу шинээр үнэ төлбөргүй дугаар олгох, төмөр замын хэрэглэгчдийн багцад шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.